



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2008 оны 07 сарын 07 өдөр

Дугаар 175

Улаанбаатар хот

”Гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх болон гадаадад үйл ажиллагаа явуулах даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 6.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.”Гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх болон гадаадад үйл ажиллагаа явуулах даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага”-ыг хавсралтаар баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ГАДААД УЛСАД САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРАА НЭЭХ
БОЛОН ГАДААДАД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ДААТГАЛЫН
МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 6.2.1 дэх заалтын дагуу олгосон тусгай зөвшөөрөл бүхий, мөн хуулийн 8.1.2, 8.1.3-т заасан даатгалын мэргэжлийн оролцогч (цаашид “мэргэжлийн оролцогч” гэх)-д гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх болон гадаадад мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (цаашид “тусгай зөвшөөрөл” гэх) олгох, түүний үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотойгоор үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх болон гадаадад үйл ажиллагаа явуулах мэргэжлийн оролцогч нь Хорооны хяналт, зөвшөөрлөөр үйл ажиллагаагаа явуулна.

1.3. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 5.3-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр бусдад шилжүүлж үл болно.

ХОЁР. Гадаадад салбар, төлөөлөгчийн газраа нээх болон гадаадад үйл ажиллагаа явуулах даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага

2.1. Мэргэжлийн оролцогч нь Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээнэ.

2.2. Мэргэжлийн оролцогч нь гадаад улсын нутаг дэвсгэрт өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг нээж ажиллуулахдаа Хорооноос зөвшөөрөл авна. Хороо дараах шалгуур үзүүлэлтийг үндэслэн зөвшөөрөл олгоно. Үүнд:

2.2.1. Гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх мэргэжлийн оролцогч нь тухайн улсад мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах 3-аас доошгүй жилийн бизнес төлөвлөгөөтэй байх, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай судалгааны материалтай байх;

2.2.2. Мэргэжлийн оролцогч нь 3-аас доошгүй жилийн мэргэжлийн оролцогчийн бизнесийн дадлага, туршлагатай байх;

2.2.3. Мэргэжлийн оролцогч нь салбаруудтайгаа мэдээллийн нэгдсэн нэг сүлжээнд холбогдож, мэдээллийн электрон баазтай болсон байх;

2.2.4. Мэргэжлийн оролцогчийн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчинтэй байх;

2.2.5. Мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны хэлбэрээ тодорхойлсон байх. Давхар даатгалын, эсхүл ердийн болон урт хугацааны даатгалын гэрээний алинд зуучлах талаар чиглэлээ тодорхойлсон байх;

2.2.6. Салбар, төлөөлөгчийн газрын ажилтан нь даатгалын мэргэжлийн оролцогчийн чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх;

2.2.7. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 11.8 болон Хорооны 2007 оны 193 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-т заасан тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан удирдах ажилтантай байх;

2.2.8. Хороо мэргэжлийн оролцогчийн салбар, төлөөлөгчийн газрын эрхлэх даатгалын мэргэжлийн оролцогчийн төрөл, даатгалын ангилал, төрөл, хэлбэрээс хамааран шаардлагатай гэж үзсэн нэмэлт нөхцөл, шаардлага тавьж болно.

ГУРАВ. Гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх болон гадаадад үйл ажиллагааявуулах даатгалын мэргэжлийн оролцогчоос бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт

3.1. Гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх болон гадаадад үйл ажиллагаа явуулахыг хүссэн мэргэжлийн оролцогч Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 10 дугаар зүйл, энэ журмын 2-т тус тус заасны дагуу дараах баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ. Үүнд:

3.1.1. Гадаад улсад үйл ажиллагаа явуулах талаар Хороонд хандаж ирүүлсэн мэргэжлийн оролцогчийн хүсэлт;

3.1.2. Гадаад улсад салбар, төлөөлөгчийн газар байгуулах тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр;

3.1.3. Мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, эсхүл уг гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

3.1.4. Төлөөлөгчийн газартай байгуулах гэрээний төсөл;

3.1.5. Салбар, төлөөлөгчийн газрын дотоод хяналтын болон бусад үйл ажиллагааг зохицуулах журам;

3.1.6. Салбар, төлөөлөгчийн газрын удирдлагын тодорхойлолтыг Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3 дугаар хавсралтаар гаргаж, иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт;

3.1.7. Гадаад улсад мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах 3-аас доошгүй жилийн бизнес төлөвлөгөө;

3.1.8. Гадаад улсын мэргэжлийн оролцогчийн зах зээлийн талаарх мэдээлэл судалгааны материал;

3.1.9. Мэргэжлийн оролцогч нь 3-аас доошгүй жилийн мэргэжлийн оролцогчийн бизнесийн дадлага, туршлагатайг нотлох баримт, тодорхойлолт;

3.1.10. Шаардлагатай гэж үзвэл Хороо нэмэлт материал шаардаж болно.

ДӨРӨВ. Хорооноос гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх болон гадаадад үйл ажиллагаа явуулах даатгалын мэргэжлийн оролцогчид зөвшөөрөл олгох, татгалзах, хүчингүй болгох

4.1. Тусгай зөвшөөрөл олгохыг хүсч мэргэжлийн оролцогчоос ирүүлсэн баримт бичгийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11, 12 дугаар зүйл, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 11.1, энэ журмын 3.1-д дурдсан баримт бичгийг үндэслэн хянаж, шаардлагатай баримт материалыг шалгаж баталгаажуулсны үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгох тухай асуудлыг Хороо шийдвэрлэнэ.

4.2. Тусгай зөвшөөрөл олгох эсэхийг Хороо мэргэжлийн оролцогчоос ирүүлсэн өргөдлийг хүлээн авсан өдрөөс хойш Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу ажлын 45 өдрийн дотор шийдвэрлэнэ. Хэрэв бичиг баримтыг зайлшгүй магадлан шинжлэх, нэмж тодруулах шаардлагатай бол энэ хугацааг нэмэлт материалыг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлж ирүүлсэн өдрөөс эхлэн тооцно.

4.3. Тусгай зөвшөөрөл олгох тухай Хорооны шийдвэрт мэргэжлийн оролцогчийн тухайн салбарт даатгалын ямар ангилал, төрөл, хэлбэрээр болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрөл олгосныг тусгана.

4.4. Тусгай зөвшөөрөл олгох тухай Хорооны шийдвэр болон Хорооноос баталсан “Даатгалын компани болон даатгалын мэргэжлийн оролцогчоос төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ”-нд заасны дагуу зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримтыг үндэслэн мэргэжлийн оролцогчийн тухайн салбарт Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3.1.4-т заасан үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоно.

4.5. Хороо нь мэргэжлийн оролцогчийн салбарт олгосон тусгай зөвшөөрлийг бүртгэн авч, зохих зааврын дагуу нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

4.6. Мэргэжлийн оролцогчийн салбар, төлөөлөгчийн газар нь Хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойших хугацаанд тусгай зөвшөөрөл авахаар анх бүрдүүлж ирүүлсэн баримт бичигт өөрчлөлт орсон тухайн бүрт уг өөрчлөлтийн талаарх мэдээллийг ажлын 10 өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

4.7. Хороо дараах үндэслэлээр гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх болон гадаадад үйл ажиллагаа явуулах мэргэжлийн оролцогчид тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана. Үүнд:

4.7.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл болон энэ журамд заасан шаардлагыг хангаагүй;

4.7.2. Хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь нотлогдсон;

4.7.3. Мэргэжлийн оролцогч нь олон улсын санхүүгийн зах зээлд гарсан гэмт хэрэгтэй холбогдож шийтгэгдсэн нь тогтоогдсон тухай мэдээлэл ирсэн;

4.7.4. Хорооноос мэргэжлийн оролцогчийг мөнгө угаах, алан хядах ажиллагааг санхүүжүүлэхтэй холбогдсон байж болохыг тогтоосон;

4.7.5. Бусад хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй.

4.8. Мэргэжлийн оролцогчийн салбарт тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд Хороо энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг өргөдөл гаргасан мэргэжлийн оролцогчид албан бичгээр мэдэгдэнэ.

4.9. Хороо хуурамч баримт бичиг бүрдүүлсэн үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд энэ хугацаанаас хойш 5 жилийн дотор тухайн мэргэжлийн оролцогчийн салбар компанийн хөрөнгө оруулагчид, гүйцэтгэх удирдлага (гүйцэтгэх захирал, ерөнхий менежер, ерөнхий нягтлан бодогч, эсхүл тэдгээртэй адилтгах албан тушаал)-д ажиллах этгээдээс тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг дахин хүлээн авахгүй.

4.10. Хороо мэргэжлийн оролцогчид гадаад улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх мэргэжлийн оролцогч нь тухайн улсад мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгосон тухайгаа олон нийтэд мэдээлнэ.

4.11. Мэргэжлийн оролцогч нь салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгах, өөрчлөн байгуулах (нэгтгэх, нийлүүлэх, салгах, тусгаарлах, өөрчлөх), байршлыг нь өөрчлөх (хооронд нь солих, шилжүүлэх) тухай бүрд шийдвэр гаргаж, уг шийдвэрийг гаргасан өдрөөс хойш ажлын 3 өдрийн дотор Хороонд ирүүлж, зөвшөөрөл авсны үндсэн дээр хэрэгжүүлнэ.

4.12. Мэргэжлийн оролцогчийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгож, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд ажлын 5 өдрийн дотор энэ тухай тэмдэглэл хийнэ. Үүнд:

4.12.1. Салбар, төлөөлөгчийн газрыг татан буулгах болон үйл ажиллагааг зогсоох талаар гаргасан тухайн мэргэжлийн оролцогчийн удирдлагын шийдвэр;

4.12.2. Гадаад улсын харьяалах хяналтын байгууллагаас гаргасан шийдвэр;

4.12.3. Хороо нь тухайн мэргэжлийн оролцогч, мэргэжлийн оролцогчийн салбар, төлөөлөгчийн газар санхүүгийн хүндрэлд орсон, холбогдох хууль тогтоомжид нийцээгүй үйл ажиллагаа явуулсан, Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй буюу тухайн салбарын санхүүгийн байдал мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэр гаргаж олгосон зөвшөөрлөө хүчингүй болгох;

4.12.4. Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

ТАВ. Хяналт, хариуцлага

5.1. Хороо гадаад улсад үйл ажиллагаа эрхэлдэг Монгол Улсын мэргэжлийн оролцогчийн салбар, төлөөлөгчийн газрын бүртгэл хөтөлнө.

5.2. Хороо гадаад улсад үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд хяналт тавихдаа гадаадын хяналтын байгууллагатай хамтарч болно.

5.3. Хороо олгосон зөвшөөрөл болон тухайн салбар, төлөөлөгчийн газарт зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэрээ гадаадын хяналтын байгууллагад албан ёсоор хүргүүлж болно.

5.4. Хороо мэргэжлийн оролцогчийн төлбөрийн чадварын байдалд байнгын хяналт тавина. Хэрэв төлбөрийн чадвар хангалтгүй, тухайн гадаад улсад явуулж буй бизнесийг удирдаж чадахгүй, хөрөнгийн чадавхи хүрэлцээгүй болсон бол гадаадад тухайн бизнесийн үйл ажиллагаа эрхлэхийг зогсоож болно.

5.5. Хороо гадаад улс дахь мэргэжлийн оролцогчийн салбарын болон төв компанийн тайлан, түүний дотоод хяналтын үйл ажиллагаанд хяналт тавина.

5.6. Хороо мэргэжлийн оролцогчийн салбарын санхүүгийн тайлангийн бодитой эсэхэд бие даан шалгалт хийх, эсвэл энэ талаар гадаадын байгууллагатай зөвшилцөх, мөн гадаадын байгууллагад шалгуулах хүсэлтээ тавьж болно.

5.7. Гадаад улсад үйл ажиллагаа явуулах мэргэжлийн оролцогч болон мэргэжлийн оролцогчийн салбар, төлөөлөгчийн газар нь энэ журмаар тавигдсан шаардлагын биелэлтийн тайланг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Хороонд ирүүлнэ.

5.8. Хорооноос энэ журмын биелэлтэд хяналт тавьж гадаад улсад үйл ажиллагаа явуулах мэргэжлийн оролцогч болон мэргэжлийн оролцогчийн салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд газар дээрх шалгалтыг хийж, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 18.1, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 45.1-д заасны дагуу тус тус хариуцлага хүлээлгэнэ.

ЗУРГАА. Бусад зүйл

6.1.Энэ журмаар зохицуулагдаагүй тусгай зөвшөөрлийн холбогдолтой аливаа асуудлыг Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, даатгалын багц дүрэм болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

--ooOoo--